

**Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр (2004-2008 он)-ийн
хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан**

2008 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1	Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	Засгийн газрын 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 220 дугаар тогтоол
2	Хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийн үргэлжлэх хугацаа	2004-2008 он
3	Хөтөлбөрийн зорилго	Хоршооны эрх зүй, эдийн засгийн орчныг сайжруулж, Засгийн газар болон хоршоог дэмжигч төрийн болон төрийн бус байгууллагууд түншлэлийн үндсэн дээр хамтран ажиллаж хоршооны гишүүдийн аж амьдралыг сайжруулах, гишүүддээ үйлчлэх нөхцөл байдлыг дээшлүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулахад оршино.
4	Хөтөлбөрийн зорилтууд	1.Хоршоо болон хоршоог дэмжигч салбарын онцлогийг тусгасан эрх зүйн орчныг боловсронгуй болгох, 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн байгууллагуудын үүрэг, оролцоог дээшлүүлэх, 3.Хоршоод өөртөө чухал хэрэгцээтэй байгаа үйлчилгээ (ялангуяа хөрөнгө оруулалт, зээл, даатгал, лизингийн үйлчилгээ, аудит, технологи)-г нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, 4.Бүсийн болон үндэсний хэмжээний зөвлөлгөө өгөх, мэдээлэл солилцох тогтолцоог хөгжүүлэх,
5	Хүлээгдэж буй үр дүн	1.Хоршоодын холбоод болон хоршоог дэмжигч байгууллагуудтай хамтран ажиллаж, хоршооны санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны бүртгэл тооцооны системийг боловсронгуй болгоно. 2.Орон нутагт хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдэд ЖДҮ-ийг хоршооны хэлбэрээр эрхлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ. 3.Хоршооны эрх зүйн орчинг боловсронгуй болгосноор хоршоо хөгжих таатай орчин бүрдэнэ.
6	Зардал (сая.төг)	Төсөв(шаардагдах нийт зардал) 1817,0 сая төгрөг
	Гүйцэтгэл(өссөн дүнгээр)	Нийт-1290,2 сая₮. (Үүнд:төсвөөс-198,7сая₮, АХБ-ны ХАА-н салбарын хөгжил төслөөс-49,5сая₮, ГТХАН-ийн “ХБМС” төслөөс-163,2 мян.евро*1500=245 сая₮, Францын тусламжийн сан-407,0сая₮, Хөрөнгө оруулалтыг дэмжих сангаас-390,0 сая₮)
7	Хөтөлбөрийн хэрэгжилт (хүрсэн үр дүн, үр ашиг, үр нөлөө)	Улсын хэмжээнд 2004 онд 2636 хоршоод 18721 гишүүдтэй байсан бол 2008 онд хоршоодын тоо 1695(ХЗХоршоод татан буугдсантай холбоотой), гишүүдийн тоо 212589-д хүрсэн нь хоршооны тоо 35,7%-иар буурч, гишүүдийн тоо 11,3 дахин нэмэгдсэн нь иргэд хамтын хөдөлмөрийн давуу талыг ойлгож, хоршооны удирдлага, зохион байгуулалт сайжирч хоршооны гишүүдийн амьдралын түвшин дээшилж байгааг харуулах эерэг үзүүлэлт гэж дүгнэж байна.Нэг хоршоо дунджаар 125 гишүүнтэй байна. “Хоршооны тухай” хуулинд 1998 онд шинэчилсэн найруулга, 2002 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь “Хоршоод хуулиар хориглоогүй ямар ч үйл ажиллагааг явуулах эрхтэй болж олон төрөлт хоршоод хөгжих, ялангуяа ХЗХоршоодын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг илүү тодорхой болгож өгсөн, 2004 онд “Давхар татвар ногдуулахгүй байх”, 2005 онд “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулинд ХАА-н анхдагч бүтээгдэхүүн мах, сүү, өндөг, арьс шир, үр

			<p>тарианы дотоодын үйлдвэрлэлд нийлүүлсэн үнэд нэмэгдсэн өртгийн албан татварын 10% шингэсэн байхаар өөрчлөлт оруулж тусгасан нь хоршоог хөгжих эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчин бий болгоход чухал ач холбогдолтой болсон. Хоршоог тодорхой нэг чиглэлийн төдийгүй хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхэлж болохоор хуульчлагдсан. Хоршоод дангаараа эсвэл бусад хуулийн этгээдтэй хамтарч “Дундын хоршоо” байгуулахаар заасан нь хоршооны хөгжилд шинэ хандлага авчирч байна. 2008 онд хуулинд дахин нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг ажиллан үзэл баримтлалын шинэчилсэн төслийг хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна. 17 аймагт Хоршоог дэмжих төвүүд байгуулагдаж, үндэсний-1, салбарын- 5 холбоод, ҮЗ, орон нутгийн салбар зөвлөлүүд гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажилласнаар “Улсын тэргүүний 10 гаруй хоршоодыг түшиглэн харилцан туршлага солилцох “Бүсчилсэн үзүүлэх сургалт”-уудыг зохион байгуулсан нь Хоршооны үүрэг, ач холбогдлын талаархи ойлголт нийгмийн сэтгэл зүйд тодорхой ахиц гарсныг харуулж байна.</p>							
8	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь 84,7%	Дүн	100	90	80	70	60	50	0
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо	4		1	2	1			
9	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл		төлөвлөсөн			гүйцэтгэл			хувь	
Шалгуур үзүүлэлт	Хоршооны болон гишүүдийн тооны өсөлт	төлөвлөөгүй 2004 онд-2636 2004онд-18721	1695 212589			64,3% 11,3дахин				
	Ажиллагсадын тооны өсөлт	Төлөвлөөгүй 2004 онд-9146	59000			6,4 дахин өссөн				
	Хоршооны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлж байгаа хувь нэмэр	Нийт хоршоодын 29,0% нь-ХАА-н, 11,0% нь – боловсруулах үйлдвэр, 12%-санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд эдгээр хоршоод нийт 110,4 тэрбум ₮-ийн борлуулалт хийж, гишүүддээ 290,4 сая ₮-ийн ногдол ашиг хуваарилжээ.								
	Хоршоо хоорондын болон дэмжигч байгууллагуудын түншлэлийн байдал	Хоршоог дэмжих төвийг 17 аймагт байгуулж, гадаадын төсөл, хөтөлбөрүүдэд хамруулж, тухайлбал ГТХАН-ийн “ХБМС” төсөлтэй хамтарч ажиллав.								
	Хоршоонд зориулсан хөрөнгө оруулалт,	1817,0 сая ₮	1290,2 сая ₮.			71,0%				
	Даатгал, лизингийн үйлчилгээнд хамрагдсан хоршооны хувь, өсөлт	Статистик тоо байхгүй.								
	Хууль эрх зүйн орчныг сайжруулах	2004 онд “Давхар татвар ногдуулахгүй байх”, 2005 онд “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулинд ХАА-н анхдагч бүтээгдэхүүн мах, сүү, өндөг, арьс шир, үр тарианы дотоодын үйлдвэрлэлд нийлүүлсэн үнэд нэмэгдсэн өртгийн албан татварын 10% шингэсэн байхаар өөрчлөлт оруулж тусгасан нь хоршоог хөгжих эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчин бий болгоход чухал ач холбогдолтой болсон. Хоршоод дангаараа эсвэл бусад хуулийн этгээдтэй хамтарч “Дундын хоршоо” байгуулахаар заасан нь хоршооны хөгжилд шинэ хандлага авчирч байна.								

1 0	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<ul style="list-style-type: none"> Хоршоо сонгомол хэлбэрлүүгээ орж чанар нь сайжирсан. Үр өгөөж, нийгэмд үзүүлж буй хамралт нь дээшилж, хоршоод зах зээлд өрсөлдөх чадвартай “Брэнд” бүтээгдэхүүнтэй болсон. Гишүүдийн тоо нэмэгдэн, хоршооны удирдлага, зохион байгуулалт сайжирч байгаа нь иргэд хамтын хөдөлмөрийн давуу талыг ойлгож, гишүүдийн амьдралын түвшин дээшилж байна. ОУ-ын болон Үндэсний хоршооллын өдрүүдийг угтан “Хоршооллын дуу хоолой” радио нэвтрүүлэг, MN, TV9 телевизээр Форум нэвтрүүлэг-2 удаа явуулж, Зууны мэдээ сонинд цуврал нийтлэл гаргасан нь мэдээллийн салбарт ахиц гарч, нийгмийн сэтгэл зүйд өөрчлөлт ороход нөлөөлсөн. <p>Дутагдалтай тал: Хөтөлбөрт тусгагдсан хоршоодоор гүйцэтгүүлэх гэрээт ажил үйлчилгээнүүд биелээгүй, зээл, даатгал, лизинг, аудитын эрх зүйн орчин бүрдээгүй. Аймгуудын Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнд Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв тусгагдаагүй, иймд хариуцлага тооцох ямар нэг механизм байхгүй явж иржээ.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилт 84.7%-тай байгааг үндэслэн хөтөлбөрт “Хангалттай” гэсэн үнэлгээг өгч байна.</p>
1 1	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө төлөвлөсөн хэмжээнээс ихээхэн бага байсан тул 11 арга хэмжээ тасрахад нөлөөлсөн. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар 2008 онд хуулинд дахин нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг ажиллан үзэл баримтлалын шинэчилсэн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Цаашид хөтөлбөрийг үргэлжлүүлэх арга хэмжээний зардлыг бодитой тусгах шаардлагатай.
1 2	Хөтөлбөр хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	Хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна. Зарим яам, тусгай газрууд Үндэсний зөвлөлд тайлангаа ирүүлэхгүй, хуралд оролцохгүй байгааг анхаарч цаашид хөтөлбөрийг үргэлжлүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүргээ илүү сайн явуулах шаардлагатай.
1 3	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж	<ul style="list-style-type: none"> Холбогдох яамдын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх Хоршоог дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсөв хөрөнгийг аймгийн Засаг даргын багцад суулгаж, зохих журмын дагуу зарцуулах. “ХХНХХ”-ийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг өргөн хэмжээний далайцтай зохион байгуулах.

Төрийн нарийн бичгийн дарга

Т.Гантулга